



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/19/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Говьсүмбэр аймаг

2022 он

Дарга тэргүүлэх аудитор:

Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер:

Утас: 7054-3179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор:

Утас: 7054-3179 Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	17
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.6.3 Нэмэлт төсөв	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГСА	Говьсүмбэр аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2022.02.24 № *01*

танай _____-ны № _____-г

Г ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮНС, Г
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Н.ДАВААХҮҮ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020005

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,760,403.50	48,601,385.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	4,609,806.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	4,609,806.00
31210	Төгрөг	0	4,609,806.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0	4,609,806.00
34	УРЬДЧИЛГАА	0	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,760,403.50	16,786,579.50
35100	Түүхий эд материал	1,700,000.00	1,700,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,700,000.00	1,700,000.00
35400	Хангамжийн материал	43,060,403.50	15,086,579.50
35410	Бичиг хэргийн материал	2,058,520.00	1,803,067.00
35420	Аж ахуйн материал	15,895,883.50	61,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	381,500.00	0
35440	Түлш, шатах тослох материал	2,319,500.00	345,800.00
35460	Хүнсний материал	20,005,000.00	0
35470	Бусад хангамжийн материал	2,400,000.00	12,876,312.50
36	НӨӨЦИЙН БАРАА	0	20,005,000.00
36100	Барааны нөөц	0	20,005,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	391,736,767.41	313,276,539.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	391,736,767.41	313,276,539.04
39200	Биет хөрөнгө	216,455,445.55	197,085,217.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	249,617,547.00	249,617,547.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-62,539,755.66	-74,495,120.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,349,280.00	113,349,280.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-113,349,280.00	-113,349,280.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	67,863,093.26	67,863,093.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,112,432.61	-57,091,959.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,862,750.00	11,862,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,245,081.14	-7,167,484.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,791,940.00	30,791,940.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-23,782,615.30	-24,295,549.42
39300	Биет бус хөрөнгө	175,281,321.86	116,191,321.82
39301	Програм хангамж	7,892,500.00	7,892,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,692,500.14	-4,182,500.18
39303	Бусад биет бус хөрөнгө	170,081,322.00	112,481,322.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	436,497,170.91	361,877,924.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	436,497,170.91	361,877,924.54
51	Засгийн газрын хувь оролцоо	436,497,170.91	361,877,924.54
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	495,496,678.25	437,896,678.25

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51200	Хуримтлагдсан үр дүн	-75,883,274.02	-92,902,520.39
51210	Өмнөх үеийн үр дүн	-82,118,232.19	-77,174,774.02
51220	Тайлант үеийн үр дүн	6,234,958.17	-15,727,746.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,883,766.68	16,883,766.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	436,497,170.91	361,877,924.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	351,787,853.22	267,466,452.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,858,662.65	5,647,102.60
120	Нийтлэг татварын бус орлого	25,858,662.65	5,647,102.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	177,800.00	5,623,874.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	177,800.00	5,623,874.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	25,680,862.65	23,228.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	325,929,190.57	261,819,350.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	325,770,100.00	250,228,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	325,770,100.00	250,228,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,090.57	11,591,150.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	10,943,150.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	159,090.57	648,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	345,552,895.05	283,194,198.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	345,552,895.05	283,194,198.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,356,772.86	268,483,220.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	166,719,364.00	170,119,282.00
210101	Үндсэн цалин	134,429,364.00	130,325,270.00
210102	Нэмэгдэл	27,450,000.00	26,950,894.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,840,000.00	9,294,668.00
210104	Урамшуулал	0	3,548,450.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,760,198.81	21,453,139.56
210201	Тэтгэврийн даатгал	14,892,469.81	15,199,377.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,298,154.00	1,673,213.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,503,826.00	1,341,766.00
210204	Ажилгүйдлийн даатгал	521,297.00	294,433.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,544,452.00	2,944,350.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,479,503.00	5,785,839.00
210301	Гэрэл, цахилгаан	875,396.00	998,800.00
210302	Түлш, халаалт	4,120,407.00	4,375,600.00
210303	Цэвэр, бохир ус	483,700.00	411,439.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,835,252.22	29,774,872.60
210401	Бичиг хэрэг	2,198,476.00	3,354,753.00
210402	Тээвэр, шатахуун	6,217,390.57	11,082,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,085,494.00	1,130,500.00
210404	Ном, хэвлэл	0	0

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	166,000.00	216,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,169,391.65	9,708,519.60
210408	Бараа материал акталсны зардал	998,500.00	4,282,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,224,700.00	1,222,100.00
210604	Урсгал засвар	1,224,700.00	1,222,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,851,000.00	837,000.00
210702	Дотоод албан томилолт	1,851,000.00	837,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,613,142.00	13,568,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,054,397.00	8,967,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	448,920.00	431,595.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	208,725.00	337,125.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	122,500.00	142,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	178,600.00	90,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,873,612.83	25,722,287.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	227,800.00	4,862,059.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,645,812.83	20,860,228.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,196,122.19	14,710,978.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,320,368.00	1,010,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,320,368.00	1,010,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,875,754.19	13,700,978.44
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,875,754.19	13,700,978.44
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,234,958.17	-15,727,746.37
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	6,234,958.17	-15,727,746.37

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	495,496,678.25	16,883,766.68	-82,118,232.19	430,262,212.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	495,496,678.25	16,883,766.68	-82,118,232.19	430,262,212.74
4	Тайлант үеийн үр дүн	0	0	6,234,958.17	6,234,958.17
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	495,496,678.25	16,883,766.68	-75,883,274.02	436,497,170.91
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	495,496,678.25	16,883,766.68	-75,883,274.02	436,497,170.91
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-1,291,500.00	-1,291,500.00
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	495,496,678.25	16,883,766.68	-77,174,774.02	435,205,670.91
9	Өмчид гарсан өөрчлөлт	-57,600,000.00	0	0	-57,600,000.00
10	Тайлант үеийн үр дүн	0	0	-15,727,746.37	-15,727,746.37
11	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	437,896,678.25	16,883,766.68	-92,902,520.39	361,877,924.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	326,106,990.57	267,239,156.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	177,800.00	5,419,806.00	
120	Нийтлэг татварын бус орлого	177,800.00	5,419,806.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	177,800.00	5,419,806.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	177,800.00	5,419,806.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	325,929,190.57	261,819,350.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	325,770,100.00	250,228,200.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	325,770,100.00	250,228,200.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,090.57	11,591,150.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	10,943,150.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	159,090.57	648,000.00	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	325,006,990.57	262,629,350.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	325,006,990.57	262,629,350.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,810,868.38	247,871,971.56	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	128,952,200.00	169,915,214.00	
210101	Үндсэн цалин	96,662,200.00	130,121,202.00	
210102	Нэмэгдэл	27,450,000.00	26,950,894.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,840,000.00	9,294,668.00	
210104	Урамшуулал	0	3,548,450.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,408,600.00	21,453,139.56	
210201	Тэтгэврийн даатгал	12,250,500.00	15,199,377.56	
210202	Тэтгэмжийн даатгал	1,289,500.00	1,673,213.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,031,600.00	1,341,766.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	257,900.00	294,433.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	2,579,100.00	2,944,350.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,479,503.00	5,785,839.00	
210301	Гэрэл, цахилгаан	875,396.00	998,800.00	
210302	Түлш, халаалт	4,120,407.00	4,375,600.00	
210303	Цэвэр, бохир ус	483,700.00	411,439.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	12,431,890.57	9,174,600.00	
210401	Бичиг хэрэг	1,756,900.00	906,800.00	
210402	Тээвэр, шатахуун	5,164,890.57	5,463,300.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,400,600.00	1,333,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	284,200.00	216,000.00	

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,825,300.00	1,255,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,362,350.00	1,456,100.00
210604	Урсгал засвар	1,362,350.00	1,456,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,851,000.00	837,000.00
210702	Дотоод албан томилолт	1,851,000.00	837,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	154,011,324.81	27,930,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	152,452,579.81	16,129,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	448,920.00	431,595.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	208,725.00	337,125.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	122,500.00	142,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	178,600.00	90,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	314,000.00	11,319,579.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	314,000.00	11,319,579.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,196,122.19	14,757,378.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,320,368.00	1,056,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,320,368.00	1,056,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,875,754.19	13,700,978.44
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,875,754.19	13,700,978.44
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,100,000.00	4,609,806.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,100,000.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,100,000.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,100,000.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,100,000.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,100,000.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	4,609,806.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	4,609,806.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	250,228,200.00	236,527,221.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,228,200.00	236,527,221.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	249,171,800.00	235,470,821.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,660,200.00	169,915,214.00
210101	Үндсэн цалин	138,978,200.00	130,121,202.00
210102	Нэмэгдэл	27,450,000.00	26,950,894.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,240,000.00	9,294,668.00
210104	Урамшуулал	3,992,000.00	3,548,450.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,389,200.00	21,453,139.56
210201	Тэтгэврийн даатгал	17,162,800.00	15,199,377.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,806,600.00	1,673,213.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,445,300.00	1,341,766.00
210204	Ажилгүйдлийн даатгал	361,300.00	294,433.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,613,200.00	2,944,350.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,793,600.00	5,785,839.00
210301	Гэрэл, цахилгаан	998,800.00	998,800.00
210302	Түлш, халаалт	4,375,600.00	4,375,600.00
210303	Цэвэр, бохир ус	419,200.00	411,439.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,759,100.00	5,759,100.00
210401	Бичиг хэрэг	756,800.00	756,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,197,600.00	3,197,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,333,500.00	1,333,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	216,000.00	216,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	255,200.00	255,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	808,100.00	808,100.00
210604	Урсгал засвар	808,100.00	808,100.00
2107	Томилолт, зочны зардал	837,000.00	837,000.00
210702	Дотоод албан томилолт	837,000.00	837,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,942,600.00	27,930,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,129,000.00	16,129,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	431,600.00	431,595.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	349,200.00	337,125.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	142,000.00	142,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	90,800.00	90,780.00

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,982,000.00	2,981,929.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,982,000.00	2,981,929.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,056,400.00	1,056,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,056,400.00	1,056,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,056,400.00	1,056,400.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	250,228,200.00	236,527,221.56
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	250,228,200.00	236,527,221.56
310001	Улсын төсвөөс санхүүжих	250,228,200.00	236,527,221.56
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	35	31
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	15
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	11	7
620003	Үйлчлэх ажилтан	5	7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	17	15
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,591,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,591,150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,591,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,415,500.00
210401	Бичиг хэрэг	150,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,265,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	999,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	648,000.00
210604	Урсгал засвар	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,527,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,527,650.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,591,150.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,591,150.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,943,150.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	648,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн тогтвортой байдалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/10 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн “Хүнс, Хөдөө аж ахуйн газар” нь “Салбарын яамны эрхэм зорилго, стратегийн тэргүүлэх чиглэлийг удирдлага болгон орон нутагт хэрэгжүүлэх бодлогыг оновчтой тодорхойлж, түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, үнэ цэний сүлжээг бий болгох, хөгжүүлэх, орлого, бүтээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ХАА-н үйлдвэрлэгчдийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх замаар хүн амыг эрүүл аюулгүй, шим тэжээллэг хүнсээр жигд хүртээмжтэй хангах, эрүүл ахуй хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслийг хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлэх нөхцөлийг бүрэлдүүлэхэд оршино” гэсэн зорилт дэвшүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар” нь 2021 онд дотоод аудит, хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөнд 6 арга хэмжээ төлөвлөж гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 345,552.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,183.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,628.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн “Хүнс, Хөдөө аж ахуйн газар”-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,619.3 мянган төгрөгөөр буюу 17.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмч дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		4,609.8	-4,609.8
Урьдчилгаа		7,200.0	-7,200.0
Бараа материал	44,760.4	36,791.6	7,968.8
Үндсэн хөрөнгө	391,736.8	313,276.5	78,460.3
Нийт хөрөнгө	436,497.2	361,877.9	74,619.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	436,497.2	361,877.9	74,619.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	436,497.2	361,877.9	74,619.3

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,609.8 мянган төгрөгөөр өссөн нь төрийн сангийн дансанд байрших ахмадын сангийн дансны үлдэгдэл байна. Тайлант онд цалингийн зардлын нийт төсвийн 3 хувиар буюу 5,419.8 мянган төгрөгөөр ахмадын сан үүсгэсэн бөгөөд 810.0 мянган төгрөгийг зарцуулж, 4,609.8 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнажээ.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 7,200.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь дээд шатны төсөв захирагчаас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 10,800.0 мянган төгрөгийг баталсан ба “Дата ланд” ХХК-тай байгуулсан гэрээгээр 2021 оны үйлчилгээний төлбөрт 3,600.0 мянга, 2022 оны төлбөрт 7,200.0 мянган төгрөгийг төлөхөөр үүрэг хүлээснээс шалтгаалан урьдчилж төлсөн зардлын авлага үүсжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,791.6 мянган төгрөг болж 7,968.8 мянган төгрөгөөр буурсан нь 4,282.0 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын 2021 оны А/45 дугаар тушаалаар акталж, данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 391,736.8 мянган төгрөг байсан ба 78,460.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2019 оны А/110 дугаар захирамжийг үндэслэн 57,600.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг данснаас хасаж, 20,860.2 мянган төгрөгийн элэгдлийг байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 436,497.2 мянган төгрөгөөс 361,877.9 мянган төгрөг болж 74,619.3 мянган төгрөгөөр буурсан нь газар эзэмших эрхийг данснаас хассан 57,600.0 мянга, өмнөх онд шатахууны зарцуулаагүй үлдэгдлийг төлбөрийн актаар буцаан төвлөрүүлсний улмаас өмнөх үеийн үр дүнг бууруулсан 1,291.6 мянга, тайлант үеийн үр дүн 15,727.7 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Говьсүмбэр аймгийн “Хүнс, Хөдөө аж ахуйн газар”-ын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 84,321.4 мянган төгрөгөөр буюу 24.0 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 25,657.6 мянга, улсын төсвийн санхүүжилт 75,541.9 мянгаар тус тус буурч ахмадын сангийн орлого 5,419.8 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 11,432.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 62,358.7 мянган төгрөгөөр буюу 18.1 хувиар буурсан байна. Үүнд: бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 97,087.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үлийн цагаан оготно устгалын ажилд 96,000.0 мянган төгрөг батлагдаж байсан нь нөлөөлжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 337,193.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 337,193.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 112,692.2 мянган төгрөгөөр бууруулж, 224,501.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд тайлант хугацаанд нийт 3 удаа төсөвт өөрчлөлт оруулж, жилийн эцсийн байдлаар 250,228.2 мянган төгрөгөөр санхүүжилтийг баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70801, 70802, 70805, 72101 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 250,228.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 250,228.2 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 250,228.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 236,527.2 мянган төгрөгийг зарцуулж, 13,701.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Хөтөлбөрийн код нэр	Арга хэмжээний код, нэр	Төлөв	Гүйц	Зөрүү
70801-Мал аж ахуйг хөгжүүлэх	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал 82542-Монгол мал хөтөлбөр	800.0 6,460.0	800.0 6,460.0	0.0 0.0
70802-Газар тариалан хөгжүүлэх	82528-Ургацын комисс, төв штаб, удирдлага	5,000.0	5,000.0	0.0
70805-ХАА, Газар тариалангийн бодлого	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	233,111.8 1,056.4	219,410.8 1,056.4	13,701.0 0.0
72101-ЖДҮДэмжих	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээнд	3,800.0	3,800.0	0.0
Нийт дүн		250,228.2	236,527.2	13,701.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 5 арга хэмжээ зохион байгуулах 11,944.5 мянган төгрөгийн санхүүжилт, 864.0 мянган төгрөгийн түрээсийн орлого бүрдүүлэн нийт 12,808.5 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар бүртгэж, 11,591.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан гэрээний дагуу 216.0 мянга, зохиомол хээлтүүлгийн хэрэгжээгүй арга хэмжээний зардал 1,001.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, санхүүгийн тайланд 11,591.2 мянган төгрөгийн орлого тайлагнажээ. Гүйцэтгэлээр арга хэмжээний зардалд 11,591.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцолсон.

Тус байгууллага нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан авсан, батлагдсан төсөвт 10 хувь хүртэлх хэмнэлт гаргаагүй гэх мэт зөрчлүүд илэрсэн бөгөөд асуудлын бүртгэлд тусгаж зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгсөн.

Мөн дээд шатны төсвийн захирагчаас тэвчиж болох буюу мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 10,800.0 мянган төгрөгийг хуваарилан 2022 оны төлбөрийг урьдчилан шилжүүлж авлага үүсгэсэн нь анхаарал татаж байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформ //www.opengov.mn/-ны 2022 оны төлбөрийг урьдчилж шилжүүлэн 7,200.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар” нь 2021 онд нийт 318,490.3 мянган төгрөгийн 40 мэдээллийг байршуулахаас 25,519.1 мянган төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар” нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 5 сарын 5-ны 01/91, 10 сарын 29-ний 01/204 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 34,789.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,404.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 330,4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 27,055.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2 дугаар хавсралтын 4.21, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.3.1.3-т нийцүүлэн аж ахуйн материалаас хангамжийн материалыг салгаж, дансны ангиллын дагуу үнэн зөв бүртгүүлсэн.
2. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2 дугаар хавсралтын 4.24-т заасны дагуу аймгийн улирлын стратегийн нөөцийг нөөцийн бараа дансанд бүртгүүлсэн.
3. Төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформ //www.opengov.mn/-ын 2022 оны төлбөр 7,200.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлсэн боловч тайлант үеийн зардлаар бүртгэсэн байсныг урьдчилж төлсөн зардлаар бүртгүүлсэн.
4. Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингаас суутгасан 204.0 мянган төгрөгийн арга хэмжээний зардлыг зардал бууруулах бичилт хийснийг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. 1 ажилтанд ээлжийн амралтын олговор, цалинг давхардуулан 330.4 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 20.2.4, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 13 дахь заалтыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3, 4.2.3.6-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Завсрын аудитаар авлага, өр төлбөргүй ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. Opengov.mn-ны 2022 оны төлбөрийг урьдчилан шилжүүлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.10 дахь заалтыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

2. Тайлант онд амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийг 1,536.4 мянган төгрөгөөр худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4, 1.7 дахь заалтыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн бүхий худалдан авалтын 25,319.1 мянган төгрөгийн 3 мэдээлэл, ер төлбөр үүсгэсэн 200.0 мянган төгрөгийн 1 тушаал мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хоолны хөнгөлөлтийг өдрийн 3.0-10.0 мянга, унааны хөнгөлөлтийг 0.5-3.0 мянган болгон Төсвийн тухай хууль зөрчиж төсвийн жилийн дундуур зардал нэмэх шийдвэр гаргасан

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн жилийн дундуур зардал нэмэгдүүлэх шинжтэй аливаа шийдвэр гаргахгүй байх, гаргасан тохиолдолд дараа жилийн төсөвт тусган хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	9	34,789.9	4	7,404.0	1	330.4	3	27,055.5	1	